



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хүүхдийн 2-р цэцэрлэгийн  
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ДГА-2023/156/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.dornogovi@audit.gov.mn](http://www.dornogovi@audit.gov.mn)

Дорноговь аймаг  
Сайншанд сум  
2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 261665, 70522734  
Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр  
Утас: 70523020  
Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Т.Оюунтуяа  
Утас: 99048991

Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,  
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,  
Утас: (705) 2-27-34

Цахим хуудас: [dornogovi@audit.gov.mn](mailto:dornogovi@audit.gov.mn)

0028.02.24 № 1-6/154

тантай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**ЗАМЫН-ҮҮД СУМЫН ХҮҮХДИЙН  
2-Р ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Г. МӨНХТУНГАЛАГ ТАНАА**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хүүхдийн 2-р цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хүүхдийн 2-р цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, үр дүн, бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Илрүүлэлтээр Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих мэдээллүүдээс нийт 431.6 сая төгрөгийн 25 гүйлгээ, 1.3 сая төгрөгийн 3 шийдвэрийг хугацаа хоцроосон. Мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 36.3 сая төгрөгийн орлогын 5 гүйлгээ, 18.2 сая төгрөгийн зарлагын 2 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 9.0 сая төгрөгийн 6

0100.04.23

шийдвэрийн мэдээллийг огт мэдээлээгүй байна. Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр"; заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Санхүүгийн тайлангаарх Засгийн газрын өмчийн дүн УБГэрчилгээ дээрх өмчийн дүнгээс 28.8 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Мөн Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 7 дугаар зүйл "Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн төрөл"-ийн "7.1.3.хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлтийн" болон 14 дүгээр зүйлийн "14.2.Монгол Улсын иргэн, тус улсын нутаг дэвсгэрт оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд энэ хуулийн 6, 7, 8 дугаар зүйлд заасан улсын бүртгэлийн мэдээллийг хуульд заасан хугацаанд улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй" заалтуудтай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Анхан шатны баримтын тулгалтаар 12 харилцагчдаас 15.2 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна. Мөн үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 3.1.3-д "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтууд, НӨАТ-ын тухай хуулийн 4.1.14-т "төлбөрийн баримт" гэж тухайн төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар бүхий нэгдсэн системээр баталгаажсан, албан татвар суутган төлөгч буюу худалдаа эрхлэгчийг таних тэмдэг бүхий нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримтыг", 17.3.2-т "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" заалттай нийцэхгүй байна.

Тус байгууллагын 1 ажилтны 0.8 сая төгрөгийн цалин хөлсийг нийгмийн даатгалд тайлагнаагүй байна. Мөн Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 "Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан цалин хөлс, мөн хуулийн 55, 56, 57, 59, 64, 66, 69 дүгээр зүйлд заасан олговор" шимтгэл ногдуулах орлогын бүрэлдэхүүнд орно" заалттай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 61 нэр төрлийн анхны дансны үнэтэй, 48.0 сая төгрөгийн 146 ширхэг хөрөнгө бүртгэлтэй ба "0" үлдэгдэлтэй хөрөнгүүдийг ашиглагдаж байна. Энэ нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан "Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу

тайлагнана", 49 дүгээр зүйлд тусгасан "... дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай" заалттай нийцэхгүй байна.

Эд хөрөнгийн тооллого чанартай хийгдээгүй, тооллого дууссаны дараах хурлын тэмдэглэл хөтлөөгүй, тооцоо бодсон актад хэзээ тоолсон нь тодорхойгүй байна. Энэ нь өмч, хөрөнгө дутагдах, үр ашиггүй зарцуулагдах үр дагавартай.

Мөн УСНББОУС-1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасан "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын.....ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 20-р зүйлийн 20.2.6-д заасан "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн хуулийн заалтуудыг хангаж ажиллаагүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 9 зорилт, 22 арга хэмжээний хэрэгжилт 90 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 97.3 хувийн биелэлттэй байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т. ГАН-ӨЛЗИЙ



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>64,460,412.69</b>	<b>79,494,787.17</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	13,847,588.83
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	13,847,588.83
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	13,847,588.83
31211	Төрийн сангийн харилцах	-	13,847,588.83
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	71,540.00	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	71,540.00	-
3351	Байгууллагаас авах авлага	71,540.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	64,388,872.69	65,647,198.34
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	10,990,101.69	13,253,899.14
35110	Тусгай зориулалттай материал	9,945,263.69	11,730,509.14
35130	Эм боох материал	1,044,838.00	1,523,390.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	53,398,771.00	52,393,299.20
35410	Бичиг хэргийн материал	710,000.00	600,199.00
35420	Аж ахуйн материал	47,506,161.00	39,127,111.00
35440	Түлш, шатах тослох материал	350,000.00	10,000.00
35460	Хүнсний материал	4,692,710.00	11,973,829.20
35470	Бусад хангамжийн материал	139,900.00	682,160.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>804,507,922.08</b>	<b>786,607,234.79</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	804,507,922.08	786,607,234.79
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	741,209,033.30	723,535,679.29
39201	Барилга, байгууламж, орон сууц	719,678,540.00	779,637,188.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(57,726,912.00)	(116,841,889.49)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	70,846,530.00	68,469,230.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(48,372,494.46)	(50,195,031.41)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	89,545,780.00	84,488,670.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(49,698,202.49)	(55,670,946.81)
39214	Бусад үндсэн хөрөнгө	18,330,000.00	19,830,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,583,083.25)	(7,370,416.50)
39217	Ном	1,188,875.50	1,188,875.50
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	63,298,888.78	63,071,555.50
39301	Програм хангамж	1,122,000.00	1,122,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(787,111.22)	(1,014,444.50)
39303	Бусад биет бус хөрөнгө	62,964,000.00	62,964,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>868,968,334.77</b>	<b>866,102,021.96</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,033,519.66</b>	<b>1,092,219.53</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	3,033,519.66	1,092,219.53
<b>413</b>	<b>Өглөг</b>	3,033,519.66	1,092,219.53
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,339,248.50	1,092,019.53
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	1,694,271.16	200.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	200.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,694,271.16	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>865,934,815.11</b>	<b>865,009,802.43</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	865,934,815.11	865,009,802.43
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	93,323,900.00	93,323,900.00
51101	Өмч: - төрийн	93,323,900.00	93,323,900.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	755,533,033.90	744,120,612.43
51210	Өмнөх үеийн үр дүн	755,533,033.90	715,991,360.17
51220	Тайлант үеийн үр дүн	-	28,129,252.26
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	17,077,881.21	27,565,290.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>868,968,334.77</b>	<b>866,102,021.96</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>425,549,533.28</b>	<b>574,423,615.34</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,087,000.00</b>	<b>61,977,948.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,087,000.00	61,977,948.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,087,000.00	519,300.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,087,000.00	519,300.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	61,458,648.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>424,462,533.28</b>	<b>512,445,667.34</b>

<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	372,059,200.00	434,780,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	434,780,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	372,059,200.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	194,000.00	4,603,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	194,000.00	4,603,500.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	52,209,333.28	73,061,267.34
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	52,209,333.28	73,061,267.34
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>437,717,435.45</b>	<b>545,859,863.08</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>436,534,435.43</b>	<b>545,859,863.08</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	424,066,958.77	545,859,863.08
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	277,205,235.06	331,428,750.70
210101	Үндсэн цалин	196,178,991.26	247,563,971.73
210102	Нэмэгдэл	65,914,557.88	74,169,150.26
210104	Урамшуулал	15,111,685.92	9,695,628.71
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	35,860,629.56	41,291,739.34
210201	Тэтгэврийн даатгал	25,337,912.67	28,192,303.18
210202	Тэтгэмжийн даатгал	2,784,727.73	3,426,548.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,489,544.84	2,697,559.28
210204	Ажилгүйдлийн даатгал	494,666.64	624,956.97
210205	Эрүүл мэндийн даатгал	4,753,777.68	6,350,370.98
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	45,809,333.28	53,899,867.34
210301	Гэрэл, цахилгаан	2,638,909.28	5,667,595.34
210302	Түлш, халаалт	34,997,700.00	37,828,000.00
210303	Цэвэр, бохир ус	8,172,724.00	10,404,272.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	7,190,121.00	8,589,279.55
210401	Бичиг хэрэг	856,300.00	3,214,475.00
210402	Тээвэр, шатахуун	280,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	465,360.00	-
210404	Ном, хэвлэл	108,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	752,400.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,698,541.00	1,980,400.00
210408	Бараа материал акталсны зардал	2,029,520.00	3,394,404.55
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	14,030,963.00	41,485,205.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	76,400.00	96,730.00
210502	Хоол, хүнс	13,954,563.00	41,388,475.80
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	59,998.37	6,791,320.44
210602	Тавилга	59,998.37	719,980.44
210604	Урсгал засвар	-	6,071,340.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	92,000.00	-
210702	Дотоод албан томиллолт	92,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	857,600.00	795,840.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	569,600.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	795,840.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	42,961,078.50	61,577,859.91
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	8,617,170.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	746,700.00	375,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	42,214,378.50	52,585,089.91
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	12,467,476.66	-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	200,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	-
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	12,267,476.66	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,267,476.66	-
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,183,000.02</b>	-
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	1,183,000.02	-
222001	Тоног төхөөрөмж	1,095,000.00	-
223001	Бусад хөрөнгө	88,000.02	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(12,167,902.17)</b>	<b>28,563,752.26</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	172,669.85	434,500.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	172,669.85	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	434,500.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(172,669.85)	(434,500.00)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(12,340,572.02)</b>	<b>28,129,252.26</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>426,985,037.28</b>	<b>512,445,667.34</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>4,603,500.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	4,603,500.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	-	4,603,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		4,603,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>426,985,037.28</b>	<b>507,842,167.34</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	372,059,200.00	434,780,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	434,780,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	372,059,200.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	2,716,504.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	194,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,522,504.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	52,209,333.28	73,061,267.34
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	52,209,333.28	73,061,267.34
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>393,431,564.28</b>	<b>495,598,078.51</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>393,431,564.28</b>	<b>495,598,078.51</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>380,964,087.62</b>	<b>495,598,078.51</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	261,771,037.41	331,617,690.17
210101	Үндсэн цалин	180,744,793.61	238,681,729.21
210102	Нэмэгдэл	65,914,557.88	83,050,680.52
210104	Урамшуулал	15,111,685.92	9,885,280.44
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	35,849,142.93	43,044,300.00
210201	Тэтгэврийн даатгал	25,326,426.04	29,275,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,784,727.73	3,442,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,489,544.84	2,753,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	494,666.64	688,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,753,777.68	6,884,500.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	45,809,333.28	53,899,867.34
210301	Гэрэл, цахилгаан	2,638,909.28	5,667,595.34
210302	Түлш, халаалт	34,997,700.00	37,828,000.00
210303	Цэвэр, бохир ус	8,172,724.00	10,404,272.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,959,770.00	-
210401	Бичиг хэрэг	299,900.00	-
210402	Тээвэр, шатахуун	350,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	465,360.00	-
210404	Ном, хэвлэл	108,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	752,400.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,984,110.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	19,914,923.00	48,616,295.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	488,700.00	-
210502	Хоол, хүнс	14,506,373.00	48,616,295.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,919,850.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,984,781.00	2,100,000.00
210602	Тавилга	120,900.00	-
210604	Урсгал засвар	6,863,881.00	2,100,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	92,000.00	-
210702	Дотоод албан томилолт	92,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,332,200.00	961,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,012,200.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	320,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	961,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,250,900.00	15,358,026.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	10,828,352.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,250,900.00	4,529,674.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>12,467,476.66</b>	-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	200,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	-
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	12,267,476.66	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,267,476.66	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>33,553,473.00</b>	<b>16,847,588.83</b>

5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>31,494,850.00</b>	<b>3,000,000.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>31,494,850.00</b>	<b>3,000,000.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	31,494,850.00	3,000,000.00
222001	Тоног төхөөрөмж	8,827,200.00	3,000,000.00
223001	Бусад хөрөнгө	22,667,650.00	-
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(31,494,850.00)</b>	<b>(3,000,000.00)</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	2,058,623.00	13,847,588.83
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	13,847,588.83

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	93,323,900.00	17,077,881.21	755,533,033.90	865,934,815.11
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	93,323,900.00	17,077,881.21	755,533,033.90	865,934,815.11
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	93,323,900.00	17,077,881.21	755,533,033.90	865,934,815.11
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	93,323,900.00	17,077,881.21	755,533,033.90	865,934,815.11
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(39,541,673.73)	(39,541,673.73)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	93,323,900.00	17,077,881.21	715,991,360.17	826,393,141.38
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	10,487,408.79	-	10,487,408.79
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	28,129,252.26	28,129,252.26
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	93,323,900.00	27,565,290.00	744,120,612.43	865,009,802.43

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	512,351,200.00	498,598,078.51	13,753,121.49
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	512,351,200.00	501,598,078.51	10,753,121.49
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	512,351,200.00	501,598,078.51	10,753,121.49
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	340,946,100.00	331,617,690.17	9,328,409.83
210101	Үндсэн цалин	282,447,500.00	238,973,629.21	43,473,870.79
210102	Нэмэгдэл	55,360,500.00	83,050,680.52	(27,690,180.52)
210104	Урамшуулал	3,138,100.00	9,593,380.44	(6,455,280.44)
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	43,044,300.00	43,044,300.00	-
210201	Тэтгэврийн даатгал	29,275,600.00	29,275,400.00	200.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,442,200.00	3,701,446.90	(259,246.90)
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,753,700.00	2,494,653.10	259,046.90
210204	Ажилгүйдлийн даатгал	688,400.00	688,300.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,884,400.00	6,884,500.00	(100.00)
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	53,908,800.00	53,899,867.34	8,932.66
210301	Гэрэл, цахилгаан	7,281,100.00	5,667,595.34	1,613,504.66
210302	Түлш, халаалт	38,127,700.00	37,828,000.00	299,700.00
210303	Цэвэр, бохир ус	8,500,000.00	10,404,272.00	(1,904,272.00)
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	52,922,700.00	48,616,295.00	4,306,405.00
210502	Хоол, хүнс	52,922,700.00	48,616,295.00	4,306,405.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,100,000.00	2,100,000.00	-
210604	Урсгал засвар	2,100,000.00	2,100,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	962,000.00	961,900.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	962,000.00	961,900.00	100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	18,467,300.00	21,358,026.00	(2,890,726.00)
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,937,300.00	16,833,702.00	(2,896,402.00)
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,530,000.00	4,524,324.00	5,676.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>(3,000,000.00)</b>	3,000,000.00
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	(3,000,000.00)	3,000,000.00
220001	Тоног төхөөрөмж	-	(3,000,000.00)	3,000,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	512,351,200.00	512,445,667.34	(94,467.34)
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	434,780,900.00	434,780,900.00	-
131001	Улсын төсвөөс санхүүжих	434,780,900.00	434,780,900.00	-
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	73,070,300.00	73,061,267.34	9,032.66
132001	Орон нутгийн төсвөөс	73,070,300.00	73,061,267.34	9,032.66
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	4,500,000.00	4,603,500.00	(103,500.00)
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,500,000.00	4,603,500.00	(103,500.00)
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>13,847,588.83</b>	(13,847,588.83)
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00	-
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	25.00	24.00	1.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-
620002	Гүйцэтгэх ажилтан	13.00	13.00	-
620003	Үйлчлэх ажилтан	10.00	9.00	1.00
620004	Гэрээт ажилтан	1.00	1.00	-
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	194.00	194.00	-
<b>631</b>	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	194.00	194.00	-
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	194.00	194.00	-
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>25.00</b>	<b>25.00</b>	-
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	15.00	15.00	-
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1.00	1.00	-
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8.00	8.00	-
650010	Гэрээт ажилтан	1.00	1.00	-

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нийт 50 сая төгрөгийн 4 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 50 сая төгрөгийн 4 алдааг залрууллаа. Үүнд:

#### Залруулсан алдаа:

1. Дахин үнэлгээний нэмэгдлийн дүн 10.5 сая төгрөгөөр дутуу буюу зөрүүтэй бүртгэснийг залруулсан;
2. 0.4 сая төгрөгийн бараа материал акталсаныг үндсэн хөрөнгийн гарзаар бүртгэснийг залруулсан.
3. Төсвийн гүйцэтгэлийн тайлан зөрүүтэй.
4. Дахин үнэлэгдсэн барилгын ашиглах жил 26 байхыг 41 жилээр тооцсоноор хуримтлагдсан элэгдэл 29.1 сая төгрөгөөр, тайлант хугацааны 10.0 сая төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу байгуулсныг залруулсан.

Аудитаар нийт 7 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага хүргүүлж, 5 зөвлөмж өгсөн.

#### 3.1 Төлбөрийн акт

Тайлант хугацаанд 2022 оны ажлын үр дүнг үнэлж, сумын Засаг даргын захирамжийг үндэслэн байгууллагын удирдах албан тушаалтанд 12 дугаар сард 70 хувиар буюу 0.8 сая төгрөгийг тооцож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.20-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн энэ хуулийн 14.1.18, 14.1.19-д зааснаас бусад төсвийн”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

#### 3.2 Албан шаардлага

##### 1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих мэдээллүүдээс нийт 431.6 сая төгрөгийн 25 гүйлгээ, 1.4 сая төгрөгийн 3 шийдвэрийг хугацаа хоцроосон. Мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 36.3 сая төгрөгийн орлогын 5 гүйлгээ, 18.2 сая төгрөгийн зарлагын 2 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 9.1 сая төгрөгийн 6 шийдвэрийн мэдээллийг огт мэдээлээгүй байна. Энэ нь төсөв, өмч, хөрөнгө, мөнгө шамшигдуулах, орлого нуун дарагдуулах, зориулалтын бус, үр ашиггүй зарцуулалт хийгдэх үр дагавартай.

Мөн Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:” 6.4.5 “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”; заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### **3.3 Зөвлөмж**

#### **1. Засгийн газрын оруулсан капиталтай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Санхүүгийн тайлангаарх Засгийн газрын өмчийн дүн УБГэрчилгээ дээрх өмчийн дүнгээс 28.7 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь үнэн, бодит мэдээллээр хангагдахгүй байх, хууль хэрэгжихгүй байх үр дагавартай.

Мөн Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 7 дугаар зүйл “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн төрөл”-ийн “7.1.3.хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлтийн” болон 14 дүгээр зүйлийн “14.2.Монгол Улсын иргэн, тус улсын нутаг дэвсгэрт оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд энэ хуулийн 6, 7, 8 дугаар зүйлд заасан улсын бүртгэлийн мэдээллийг хуульд заасан хугацаанд улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй” заалтуудтай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Засгийн газрын оруулсан капиталд өөрчлөлт оруулсан тохиолдолд өөрчлөлтийн талаарх бичиг баримтыг бүрдүүлэн хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлж мэдээллээ шинэчлэх.

#### **2. Төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Анхан шатны баримтын тулгалтаар 12 харилцагчдаас 15.3 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна. Энэ нь төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах үр дагавартай.

Мөн иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 3.1.3-д “анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар”-ын 6.5 “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авалтыг тооцоо хийгдсэн тухай бүрд нь цаасан болон цахим ибаримтыг үндэслэн санхүүгийн тайланд тусгаж ажиллах

#### **3. Зардлын данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Тус байгууллагын 1 ажилтны 0.8 сая төгрөгийн цалин хөлсийг нийгмийн даатгалд тайлагнаагүй байна. Энэ нь НД-ын байгууллагад үнэн зөв тайлагнаагүйгээс үүссэн зөрүүнд нөхөн шимтгэл, торгууль тавигдах үр дагавартай.

Мөн Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 “Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан цалин хөлс, мөн хуулийн 55, 56, 57, 59, 64, 66, 69 дүгээр зүйлд заасан олговор” шимтгэл ногдуулах орлогын бүрэлдэхүүнд орно” заалттай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалин хөлсийг нийгмийн даатгалын байгууллагад үнэн зөв тайлагнаж, Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

#### **4. Эргэлтийн бус хөрөнгөтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 61 нэр төрлийн 48.0 сая төгрөгийн анхны дансны үнэтэй, 146 ширхэг хөрөнгө бүртгэлтэй ба "0" үлдэгдэлтэй хөрөнгүүдийг ашиглагдаж байна.

Энэ нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт

нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана", 49 дүгээр зүйлд тусгасан "... дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай" заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 49, 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах. Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг дахин үнэлүүлэх асуудлыг шийдвэрлэх.

## **5. Дотоод хяналттай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Эд хөрөнгийн тооллого чанартай хийгдээгүй, тооллого дууссаны дараах хурлын тэмдэглэл хөтлөөгүй, тооцоо бодсон актад хэзээ тоолсон нь тодорхойгүй байна. Энэ нь өмч, хөрөнгө дутагдах, үр ашиггүй зарцуулагдах үр дагавартай.

Мөн УСНББОУС-1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасан "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын....ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 20-р зүйлийн 20.2.6-д заасан "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн хуулийн заалтуудыг хангаж ажиллаагүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодогч жилийн тайланг гаргахын өмнө тооллогыг чанартай зохион байгуулж, тооллогын үр дүнг тооцон, хянан, баталгаажуулалтыг ханган хариуцлагатай ажиллах.

Дээрх зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дахин үнэлгээний нэмэгдлийн дүн 10.5 сая төгрөгөөр дутуу буюу зөрүүтэй бүртгэснийг залруулсан.	1	10,487.4	0	-	1	10,487.4	1	10,487.4				
0.4 сая төгрөгийн бараа материал акталсаныг үндсэн хөрөнгийн гарзаар бүртгэснийг залруулсан	1	434.5	0	-	1	434.5	1	434.5				
Төсвийн гүйцэтгэлийн тайлан зөрүүтэй ирсэнийг залруулсан.	1	-	0	-	1	-	1	-				
Барилгын ашиглах жил 26 жил байхыг дахин үнэлж 41 жилээр тооцсоноор хуримтлагдсан элэгдэл 29.1 сая төгрөгөөр дутуу, тайлант хугацааны 10.0 сая төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу байгуулсныг залруулсан.	1	39,090.0	0	-	1	39,090.0	1	39,090.0				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>50,011.9</b>			<b>4</b>	<b>50,011.9</b>	<b>4</b>	<b>50,011.9</b>				

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо		
Санхүүгийн тайлангаарх Засгийн газрын өмчийн дүн УБГэрчилгээнд 64.6 сая, санхүүгийн тайланд 93.3 сая төгрөгөөр байна.	1	-					1	-				
Анхан шатны баримтын тулгалтаар 12 харилцагчдаас 15.3 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна.	1						1					

Тус байгууллагын 1 ажилтны 0.8 сая төгрөгийн цалин хөлсийг нийгмийн даатгалд тайлагнаагүй байна.	1	823.1				1	823.1			
Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 61 нэр төрлийн анхны дансны үнэтэй, 48.0 сая төгрөгийн 146 ширхэг хөрөнгө бүртгэлтэй ба "0" үлдэгдэлтэй хөрөнгүүдийг ашиглагдаж байна.	1	-				1	-			
Эд хөрөнгийн тооллого чанартай хийгдээгүй, тооллого дууссаны дараах хурлын тэмдэглэл хөтлөөгүй, тооцоо бодсон актад хэзээ тоолсон нь тодорхойгүй байна.	1	-				1	-			
Тайлант хугацаанд 2022 оны ажлын үр дүнг үнэлж, сумын Засаг даргын захирамжийг үндэслэн байгууллагын удирдах албан тушаалтанд 12 дугаар сард 70 хувиар буюу нийт 0.8 сая төгрөгийг тооцож олгосон байна.	1	827.8	1	827.8						
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>1,650.9</b>	<b>1</b>	<b>827.8</b>		<b>5</b>	<b>823.1</b>			

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих мэдээллүүдээс нийт 431.6 сая төгрөгийн 25 гүйлгээ, 1.4 сая төгрөгийн 3 шийдвэрийг хугацаа хоцроосон. Мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 36.3 сая төгрөгийн орлогын 5 гүйлгээ, 18.2 сая төгрөгийн зарлагын 2 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 9.1 сая төгрөгийн 6 шийдвэрийн мэдээллийг огт мэдээлээгүй байна.	1	-	-	-	1	-		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>		